



МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн Үндэстний гудамж 5/2, Засгийн газрын II байр,
Утас: 26 28 30, 26 61 71, Факс: (976-11) 32 09 43,
E-mail: contact@mne.gov.mn, http://www.mne.mn

2017.05.01 № 01/2482

танай 2017.04.05 -ны № 5/3216 -г

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ
АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА Ц.ГАРАМЖАВ ТАНАА

Монгол Улсын Ногоон хөгжлийн бодлого,
Төрөөс ойн талаар баримтлах бодлого, Ус
үндэсний хөтөлбөр, Уур амьсгалын өөрчлөлтийн
үндэсний хөтөлбөр, Тусгай хамгаалалттай газар
нутгийн үндэсний хөтөлбөрийн тайланг тус тус
хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт ~~98~~ хуудастай



Д.ОЮУНХОРОЛ

100346

НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ

2012 онд зохион байгуулагдсан НҮБ-ын РИО+20 бага хурлын үр дүнд гарсан “Бидний хүсч буй ирээдүй” баримт бичигт тогтвортой хөгжилд хүрэх, ядуурлыг бууруулах гол арга зам нь ногоон эдийн засаг гэж санал нэгдэн “Ногоон хөгжил”-ийн замыг сонгохыг улс орнуудад уриалж, ногоон эдийн засгийг хөгжүүлэхийг зорьж буй улс орнуудад дэмжлэг туслалцаа үзүүлж, түншлэлийг өргөжүүлэхийг хандивлагч орнуудад мөн уриалсан.

Монгол Улсын Их Хурал дэлхий нийтийн тогтвортой хөгжлийн чиг хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт тулгуурлан 2014 оны 43 дугаар тогтоолоор “Ногоон хөгжлийн бодлого”-ыг улс орны тогтвортой хөгжлийн тулгуур бодлогын нэг болгон баталж, хэрэгжилтийг хангахтай холбоотой үйл ажиллагааг зохион байгуулахыг Тогтвортой хөгжлийн үндэсний хороонд үүрэг болгосон байдаг.

Ногоон хөгжлийн бодлогод тогтвортой үйлдвэрлэл, хэрэглээг хөгжүүлэх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах, байгаль хамгаалал, хүний хөгжил, цэвэр технологийг дэмжих хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, ногоон амьдралын хэв маягийг төлөвшүүлэх, боловсрол, шинжлэх ухаан, технологи, инновацийг ногоон хөгжлийн хурдасгуур болгох, хүн амын нутагшил, суурьшлын оновчтой оновчтой бодлогыг хэрэгжүүлж, байгаль ээлтэй хот сууринг хөгжүүлэх зэрэг стратегийн зургаан зорилтыг дэвшүүлсэн.

Энэхүү бодлогын баримт бичиг нь 2015 оны 9 дүгээр сард Нэгдсэн Үндэстний Байгууллагын дээд хэмжээний чуулганаар хэлэлцэн баталсан “Тогтвортой хөгжлийн зорилт-2030” хөтөлбөр, энэхүү хөтөлбөрт нийцүүлэн Улсын Их Хурлаас 2016 онд баталсан “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030” зэрэг хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй нягт уялдаж байна.

Бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Засгийн газрын 2016 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 35 дугаар тогтоолоор баталж, стратегийн 6 зорилтын хүрээнд нийт 255 үйл ажиллагааг 2030 он хүртэл 2 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр тусгаж, 14 шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон.

Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд 2014-2017 онд холбогдох төрийн байгууллага, хувийн хэвшил, олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлсэн ажлуудыг стратегийн зорилт, түүнийг хангах арга зам бүрээр дараахи байдлаар гарган танилцуулж байна. Үүнд:

СТРАТЕГИЙН ЗОРИЛТ НЭГ: Байгалийн нөөцийн хэмнэлттэй, хүлэмжийн хийн ялгарал, хаягдал багатай үйлдвэрлэл, хэрэглээг хөгжүүлнэ.

Стратегийн гуравдугаар зорилтыг 12 арга замаар нийт 70 үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэхээр тусгагдсан.

1.1. Эрчим хүчний үйлдвэрлэл, аж үйлдвэрийн технологийг шинэчлэн үрэлгэн хэрэглээ, алдагдлыг бууруулах, үнийн бодлогыг оновчтой болгох замаар эрчим хүчний үр ашгийг 2030 он гэхэд 20 хувь нэмэгдүүлж, эрчим хүчний үйлдвэрлэлд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг 2020 он гэхэд 20 хувь, 2030 он гэхэд 30 хувьд хүргэж тус салбарт ногдох хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах

- Эрчим хүч хэмнэх, үр ашигтай хэрэглэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулах зорилгоор “Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль”-ийг 2015 онд батлан

- Байгаль орчин аялал жуулчлалын яам, Япон улсын хамтын ажиллагааны агентлагтай хамтран "Хүлэмжийн хийн тооллого хийх чадавхийг бэхжүүлэх замаар үндэсний хүлэмжийн хийн тооллогын мөчлөгийг тасралтгүй сайжруулах нь" төслийг хэрэгжүүлэхээр боллоо.

- Эрчим хүчний яамнаас хот, сум, суурин газрын цахилгаан, халаалтын систем, хэрэглээний халуун усны хангамжид нарны эрчим хүч, газрын гүний дулааныг ашиглах судалгааг хийх чиглэлээр ажиллаж байна.

- Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас Даян дэлхийн ногоон хөгжлийн байгууллагатай хатран Ховд, Архангай, Хөвсгөл аймгийн төвийн дулаан хангамжид цэвэр эрчим хүчний технологи ашиглах боломжийг тодорхойлох судалгааны ажил гүйцэтгэсэн.

- БНСУ-ын суурилагдсан салхин станц, том чадлын батарейн станц (эрчим хүч нөөцлөгч)-ийг судалж том чадлын батарейг бие даасан бичил сүлжээнд оргил ачааллыг тэгшитгэх, хүчдлийн уналтаас сэргийлэх, давтамж тохируулах зорилгоор сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдийг том чадлын эрчим хүч нөөцлөгчтэй болгох нь системийн тогтворжилтонд эерэг нөлөө үзүүлэх дүгнэлт гаргасан байна.

- Хот, сум, суурин газрын цахилгаан, халаалтын систем, хэрэглээний халуун усны хангамжид нарны эрчим хүч, газрын гүний дулааныг ашиглах судалгааг хийж, Ерөнхий сайдын захирамжаар байгалийн хийг эрчим хүчинд ашиглах санал боловсруулах ажлын хэсгийн байгуулан ажиллаж байна. Олон улсын хамтын ажиллагааны тусламжтайгаар Өмнөговь аймгийн Нарийн сухайт, Багануурын нүүрсний уурхайд судалгааны ажил хийлгэсэн болно.

1.2. Ногоон барилгын үнэлгээний систем, эрчим хүчний аудит зэрэг ногоон шийдэл, эрчим хүчний хэмнэлттэй, дэвшилтэт технологи, стандартыг нутагшуулан нэвтрүүлж, эдгээрийг дэмжих урамшуулал, хөнгөлөлтийн механизмыг хэрэгжүүлж, барилгын дулааны алдагдлыг 2020 онд 20 хувь, 2030 онд 40 хувиар тус тус бууруулах

- Барилга, хот байгуулалтын яам, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран "Ногоон хот байгуулалтын форум"-ыг 2016 оны 3-р сарын 10-11 өдрүүдэд зохион байгуулж ногоон тогтвортой хотын талаарх дэлхий нийтийн хандлага, сайн туршлага, боломжийн талаар хэлэлцсэн.

- Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамнаас захиалан Ногоон эдийн засгийн төлөөх түншлэлийн хүрээнд Сонгинохайрхан дүүргийн 122 дугаар сургуулийн 640 хүүхдийн өргөтгөлийн ногоон барилгын зураг төсөл, Даян дэлхийн ногоон хөгжлийн байгууллага, Солонгосын ногоон технологийн төвтэй хамтран 125 хүүхдийн ногоон цэцэрлэгийн барилгын жишиг зураг төслийг монгол орны цаг агаар, байгалийн нөхцөлд нийцүүлэн эцэслэн боловсруулж, Барилгын хөгжлийн төвөөр дүгнэлт гаргуулж, баталгаажуулан хүлээн авлаа.

- Ногоон эдийн засгийн T21 загварыг сайжруулах ажлын хүрээнд усны менежемент, эрчим хүч, ногоон барилга, хатуу хог хаягдал гэсэн 4 салбарын 22 дэд загварын 115 бодлогын хувьсагчид дүн шинжилгээ хийж, "Threshold 21 model for Mongolia" T21 Mongolia version 7A хэрэглэгчийн хувилбарыг боловсруулан ногоон хөгжлийн бодлогын үнэлгээний тайланг гаргаж эдгээр 4 салбар бүрт баримталж буй бодлого, хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлж, ногоон зарчим руу шилжих арга замын талаар зөвлөмж гаргаж, ногоон эдийн

шийдвэрлэж, 400 гаруй менежментийн төлөвлөгөөг хянан баталж байгаль орчныг хамгаалах чиглэлээр хийсэн ажилд үнэлэлт, дүгнэлт өгч хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

- Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг сайжруулах, гүйцэтгэлийг хангах, аж ахуйн нэгжийн тайлангийн хэрэгжилтийг газар дээр нь шалгах ажлыг жил бүр зохион байгуулж, Улаанбаатар хот, Сэлэнгэ, Дархан уул, Төв, Булган, Архангай, Өвөрхангай, Ховд, Завхан аймагуудад хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулсан.

- Ашигт малтмалын нөөц ашиглах, хайх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжүүдийн нөхөн сэргээлт хийх, байгаль орчныг хамгаалах арга хэмжээний хэрэгжилтэд тавих шаардлагыг өндөржүүлж, эвдэрсэн газрыг нөхөн сэргээх ажилд нутгийн иргэдийн оролцоог хангаж, нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээг нэмэгдүүлэх зорилт тавьж ажиллаж байна. 2016 оны байдлаар, уул уурхайн үйл ажиллагаанаас 27068.0 га талбай эвдрэлд орсноос 11375 га-д буюу 42.02%-д техникийн нөхөн сэргээлт, 7425.0 га-д буюу 27.4%-д биологийн нөхөн сэргээлтийг тус тус хийсэн байна.

- 2015-2016 онд Тавантолгой болон Багануурын бүс нутагт хуримтлагдах нөлөөлийн үнэлгээ хийж, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан.

- Уул уурхайн салбарын байгаль орчин нийгмийн стратегийн үнэлгээг хийж цаашид холбогдох салбарын бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдэд стратегийн үнэлгээ хийх ажлыг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулж байна

1.4. Хөдөө аж ахуйн тогтвортой хөгжлийг дэмжиж, ногоон технологид суурилсан экспортын баримжаатай боловсруулах үйлдвэрлэлийн кластерыг хөгжүүлж, арьс шир, ноос, ноолуур зэрэг түүхий эдийн бүрэн боловсруулалтыг 2020 онд 60 хувь, 2030 онд 80 хувьд хүргэх арга замын хүрээнд:

- Засгийн газрын 2016 оны 42 дугаар тогтоолоор “Газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтворжуулах богино хугацааны хөтөлбөр”-ийг, 90 дүгээр тогтоолоор “Малчдыг дэмжих зарим арга хэмжээний” тухай, 113 дугаар тогтоолоор “ Мал аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээмжийг дээшлүүлэх тухай, 114 дүгээр тогтоолоор “Мал аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэх дэд хөтөлбөр”-ийг тус тус батлуулан хэрэгжүүлж байна.

- Улаанбаатар, Дархан хотын гадна талд арьс ширний үйлдвэрийн цогцолбор байгуулах дэд бүтцийг барих арга хэмжээний төлөвлөгөө, тооцоог боловсруулж, шинэ бүс рүү шилжүүлэх, дэд бүтцийг барих асуудлаар Турк, Испани, Франц, Израйль, Япон Голланд Хятадын мэргэжилтэнүүдтэй хамтран ажиллаж харьцуулсан судалгаа хийв.

- Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хууль, Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах журамд нийцүүлэн дунд хугацааны стратегийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Үйлдвэржилт 21:100 хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй уялдуулан батлуулахаар боловсруулж байна.

- Ойн хаягдал, унангийг ашиглан жилдээ 30000 м3 МДФ хавтан үйлдвэрлэх хүчин чадал бүхий хавтангийн үйлдвэрт 7,140 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг

- Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах хүрээнд хүнсний бүтээгдэхүүний сав баглаа боодлын найдвартай байдлыг хангах, дотоодын үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор Засгийн газрын 2016 оны 287 дугаар тогтоолоор “Сав баглаа боодол” үндэсний хөтөлбөрийг баталсан. Энэ хөтөлбөрийг хэрэгжүүлсэнээр сав баглаа боодлын дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлж, хүний эрүүл мэнд хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөөтэй зориулалтын бус сав баглаа боодлын хэрэглээг бууруулна.

1.7. Байгаль орчин, эрүүл ахуйн шаардлага хангасан эко аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх арга замын хүрээнд:

- Байгаль орчин, аялал жуулчлалын яам, НҮБ-ын Дэлхийн аялал жуулчлалын байгууллага /UNWTO/, Дэлхийн хотуудын шинжлэх ухааны хөгжлийн холбоо олон улсын байгууллагатай /WCSDA/ хамтран “Нүүдлийн аялал жуулчлал ба хотуудын тогтвортой хөгжил” сэдэвт Торгоны замын олон улсын бага хурлыг 2016 оны 10 дугаар сард Улаанбаатар хотноо амжилттай зохион байгууллаа. Уг хуралд Торгоны замын аялал жуулчлалын хөтөлбөрийн гишүүн 21 улсын 150 гаруй олон улсын төлөөлөгчид, 200 гаруй дотоодын төлөөлөгчид оролцлоо.

- Амралтын газар, жуулчны бааз, гэр буудалд тавигдах ерөнхий стандарт болон зочид буудлын зэрэглэл тогтоох стандартыг олон ногоон зарчимд нийцүүлэн боловсруулах ажлыг зохион байгуулж байна.

- Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр бэлэн болгов.

- Тусгай хамгаалалтай газар нутгийн нөөц даацын судалгаанд үндэслэн аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулах ажлыг Германы хамтын ажиллагааны /KFW/-ын дэд төслийн хүрээнд Горхи Тэрэлжийн байгалийн цогцолборт газарт, Азийн хөгжлийн банкны төслийн хүрээнд Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газарт хэрэгжүүлэхээр зохион байгуулж байна.

- НҮБ-ын Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын дэргэдэх Тогтвортой аялал жуулчлал ядуурлыг бууруулах сангийн 65,000 ам.долларын санхүүжилтээр 2015-2016 онд “Аялал жуулчлалын салбарын хүний нөөцийг чадавхжуулах, сургагч багш нарыг бэлтгэх” төслийг амжилттай хэрэгжүүлээд байна. Төслийн хүрээнд аялал жуулчлалын сургагч багш, зочлох үйлчилгээний сургалт зохион байгуулан орон нутгийн 55 мэргэжилтэн, 250 гаруй иргэдийг сургалтанд хамруулан 270 гаруй ажилгүй иргэдийг ажлын байранд зуучлах ажлыг зохион байгуулсан.

1.8. Эрдэс баялгийн салбарт нөөцийг үр ашигтай, хаягдалгүй ашиглах технологи бүхий үйлдвэрлэлийг дэмжих арга замын хүрээнд:

- Засгийн газрын 2017 оны 20 дугаар тогтоолоор “Алт-2” үндэсний хөтөлбөрийг батлуулж, 61 дугаар тогтоолоор “Үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааны журам”, “Үүсмэл орд ашиглах үйл ажиллагаанд тавих шаардлага”-ыг батлуулаад байна.

- Ашигт малтмалын газраас ашиглалтын нөөц багатай алтны шороон болон үндсэн орд, жоншны ордод тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг зогсоогоод байна.

- Монголын байгаль орчны консорциум төрийн бус байгууллага Америкийн байгаль хамгаалах агентлагийн санхүүжилтээр нүүрсний уурхайн метан хийн нөөцийг судлаж, түүнээс ялгарч буй хүлэмжийн хийд үнэлэлт өгөх төсөл хэрэгжүүлсэн.

- Тавантолгойн нүүрсний хийн нөөцийг ашиглан, нийслэлийг цахилгаан, дулаанаар хангах зорилгын хүрээнд “Эрдэнэс Тавантолгой”, “Элгэн” болон Солонгосын төрийн өмчийн “Korea Gas”-ын хамтран нүүрсний давхаргын метан хий олборлох төслийг хэрэгжүүлж байна.

1.11. Уул уурхайн салбарын орлогоос баялгийн сангийн хуримтлалыг бий болгон урт хугацааны тогтвортой хөгжлийг хангахад зарцуулах арга замын хүрээнд:

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлагаар Ирээдүйн өв сангийн тухай хуулийг боловсруулж, УИХ-аар 2016 онд батлуулж, нөхөн сэргээгдэхгүй эрдэс баялгаас төсөвт төвлөрүүлсэн орлогыг өнөө ба хойч үеийнхэнд тэнцвэртэй хуваарилах зарчмыг хэрэгжүүлэх зорилгоор макро эдийн засгийн тогтвортой, үр ашигтай удирдлагын тогтолцоог бүрдүүлэх нөхцлийг бий болгосон.

1.12 Байгальд орчинд ээлтэй, хүний эрүүл мэнд болон биологийн олон янз байдалд сөрөг нөлөөгүй дэд бүтэц, тээврийн сүлжээг хөгжүүлэх арга замын хүрээнд:

- “Тал хээр, говь цөлийн бүсийн авто болон төмөр зам дагуу зэрлэг амьтдад зориулсан гарц, гармын ерөнхий шаардлага”, “Төмөр замын барилгын ажил, байгууламжид тавих шаардлага” зэрэг стандартуудыг батлуулан мөрдөж байна.

- Зам, тээврийн хөгжлийн яамнаас уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлтийг хатуу хучилттай авто замаар гүйцэтгүүлэх бодлого баримтлан ажиллаж байна. Тухайлбал, нүүрсний тээвэрлэлтийн зарим томоохон шороон авто замын чиглэл хаах арга хэмжээ авсан бөгөөд Таван толгой-Гашуун сухайт чиглэлийн 239 км, Нарийн сухайт – Шивээхүрэн чиглэлд 43,2 км, Хөшөөтийн уурхайгаас Булган боомтын чиглэлд 311 км хатуу хучилттай авто замаар нүүрсний тээвэрлэлтийг гүйцэтгүүлж байна. Газрын тосны тээвэрлэлтийн хувьд “Петро чайна дачин тамсаг” ХХК Дорнод аймгийн Тамсаг газрын тосны ордоос Баянхошуу боомт чиглэлд 100 км хатуу хучилттай авто зам барьж байна.

- “Улаанбаатар хотын дэд бүтцийн мастер төлөвлөгөө”-г боловсруулан Улаанбаатар хотын 10 уулзварт замын хөдөлгөөний аюулгүй байдлын хяналтын систем, шуурхай удирдлагын нэгдсэн болон дата төв, тусгай зориулалтын хамгаалалтын сүлжээг нэвтрүүлэх ажлууд тусгагдсан байна.

- Замын хөдөлгөөний нэвтрэх чадварыг нэмэгдүүлэн, ачаалалыг бууруулж, автомашинаас ялгарах бохирдолыг багасгах зорилгоор улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2016 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний хүрээнд Хүннүгийн гудамжны авто замын засвар, М.Гандийн гудамжны 1.6 км, Баянмонгол хорооллын урд талын 1,1 км авто замын шинэчлэлт, Зайсангийн гудамжнаас “Жапан Таун” хотхон хүртэлх 0,75 км авто замын өргөтгөл, шинэчлэлтийн ажил хийгдсэн. Их Монгол Улсын гудамжны 2.1 км авто замын ажлыг эхлүүлэн 2,5 км урт 14 м өргөн, дугуйн болон явган зам, борооны ус зайлуулах шугам, гадна гэрэлтүүлгийн ажлыг бүрэн дуусгаж, ашиглалтанд оруулсан.

- Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдэгдэж буй нийт нислэгийн 90 гаруй хувь нь өнгөрөлтийн нислэг байдаг тул агаарын хаалганаас хаалганд чиглэсэн шулуун, аюулгүй ажиллагааг хангасан агаарын замууд тогтоох, агаарын замуудыг богиносгох нь агаарын тээвэрлэгчдэд эдийн засгийн хувьд хэмнэлттэй, байгаль

- Увс нуурын хотгорын хил дамнасан дархан газрын Орос-Монголын хамтарсан комиссын 3-р хуралдаанаар 2016-2017 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан.

2.2 Байгалийн нөөцийн үндэсний парк, байгаль, соёлын өв газар нутагт уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхлэхийг хязгаарлан, ногоон хөгжлийн жишиг нутаг болгон эко аялал жуулчлал, уламжлалт мал аж ахуйг хөгжүүлэх арга замын хүрээнд:

- Олон улсад болон дотооддоо Хүн ба шим мандлын нөөц газрын хөтөлбөрт нэгдсэн газруудын хамгаалалтыг сайжруулах арга хэмжээг хамгаалалтын захиргааны менежментийн төлөвлөгөөтэй уялдуулан хэрэгжүүлж байна. ЮНЕСКО-ийн Хүн ба Шим мандлын нөөц газрын хөтөлбөрт нэгдсэн газруудын хамгаалалтын арга хэмжээг сайжруулах ажлын хүрээнд Хүн ба шим мандлын нөөц газарт бүртгэлтэй 6 газрын хилийн цэсийг тогтоосон шийдвэрийн төслийг боловсруулаад байна.

- Байгалийн унаган төрхөө хадгалсан газар, цэнгэг усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийг 2030 он хүртэл улсын тусгай хамгаалалтад авах бодлогын хүрээнд суурь судалгаа хийгдэх газруудын зураглалыг олон улсын Байгаль хамгаалах байгууллага /TNC/-тай хамтран ArcGIS программ ашиглан боловсруулж, судалгаа гаргасан. Түүнчлэн Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр орон нутгийн иргэдийн оролцоонд тулгуурлан аялал жуулчлалыг хөгжүүлэх замаар нутгийн ард иргэдийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэн, амьжиргааны түвшинг дээшлүүлэх зорилготой “Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газрын орчны бүсийн иргэдийн амьжиргааг дэмжих, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх нэгдсэн төсөл”-ийг 2016 оноос хэрэгжүүлж байна.

- НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага /ХХААБ/-аас санал болгосны дагуу үндэсний ач холбогдол бүхий хөдөө аж ахуйн өв газар нутгыг тогтоох, хамгаалалтад авах, цаашид даян дэхийн өв болгон бүртгүүлэх дарааллыг баримтлан ажиллаж байна. Иймд үндэсний ач холбогдол бүхий хөдөө аж ахуйн өв газар нутгийн асуудлыг хамтад нь хөгжүүлэх зорилгоор даян дэлхийн хөдөө аж ахуйн уламжлалт өвийг хөгжүүлэх тогтолцоог Монгол Улсад нэвтрүүлэх Үндэсний зөвлөлийг байгуулсан. Цаашид үндэсний ач холбогдол бүхий хөдөө аж ахуйн өв газар нутгаа тогтоох, хамгаалалтад авах, даян дэлхийн өв болгон НҮБ-ын ХХААБ-д дэвшүүлэн, бүртгүүлэхээр Үндэсний зөвлөлийн 2 тогтоолын төсөл боловсруулаад байна.

2.3 Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөг сааруулах, дасан зохицох үндэсний чадавхыг бэхжүүлэх арга замын хүрээнд:

- БОАЖЯ-наас Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенцийн Парисын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг боловсруулж, УИХ-ын 2016 оны 9-р сарын 01-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулав. Засгийн газрын Тусгай сангийн тухай хуульд 2017 оны 02 сарын 09-ний өдрийн хуулиар уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, хүлэмжийн хийг бууруулах үйл ажиллагааны санхүүжилтэд дэмжлэг үзүүлэх гэсэн нэмэлт өөрчлөлт оруулж, Байгаль хамгаалах сан нэрийг Байгаль орчин, уур амьсгалын сан (БОУАС) болгон санхүүгийн үндсэн нэгжээр тодорхойлсон.

- НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенц (УАӨСК)-ийн санхүүгийн үндсэн механизм нь Уур амьсгалын ногоон сан /УАНС/ юм. Монгол Улсын хувьд Байгаль орчин, аялал жуулчлалын яам нь УАНС-тай харилцах эрх бүхий

- Дасан зохицох сангийн санхүүжилтээр НҮБХХ-тэй хамтран хэрэгжүүлж байгаа “Экосистемд түшиглэсэн дасан зохицох арга хэмжээг уур амьсгалын өөрчлөлтөд өндөр эрсдэлтэй сав газруудад хэрэгжүүлэх нь” төсөл 2012-2017 онд Улз, Хархираа-Түргэний сав газруудад хэрэгжиж байна.

2.4. Биологийн олон янз байдлын удмын санг хамгаалах, тархац нутаг, амьдрах орчныг тэтгэх замаар хомсдолоос сэргийлж, ашиглалтын нөөц бүрдүүлэх арга замын хүрээнд:

- Засгийн газрын 2015 оны 325 дугаар тогтоолоор “Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр”-ийг батлуулсан. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийг БОАЖ-ын сайдын 2016 оны А/102 тоот тушаалаар байгуулан ажиллуулж, төслийг боловсруулаад байна.

- Монгол орны шувууны ангилал зүйг олон улсын стандартын түвшинд боловсруулж, хэвлэлтэнд өгөхөд бэлэн болсон.

- Монгол орны нэн ховор амьтан, ургамал, бичил биетний нутгийн омгийн эд, эсийн генобанк байгуулах Техник, эдийн засгийн үндэслэл боловсруулж холбогдох санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр Хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгаад байна.

- БОАЖЯ-наас дараах 3 төслийг 2017 оноос Шинжлэх ухаан, технологийн сангаар дамжуулан хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Монгол орны ховордсон зарим хөхтөн амьтад, устгах аюулд ороод байгаа ургамлын тархац, нөөцийг тогтоож, зүйлийн экологи-эдийн засгийн үнэлгээг шинэчлэн боловсруулах;
2. Эмийн болон цайны ургамлын тархац, нөөцийн судалгаа хийх, генийн санг хадгалсан тарималжуулах туршилтыг хийх, ашигт ургамлын плантаци байгуулах ажлыг турших;
3. Монгол орны амьтан, ургамал, бичил биетний ангилал зүйн бүртгэлийн мэдээллийн сан бүрдүүлэх.

- Дэрэвгэр жиргэрүү, орос махирас, чихэр өвс гэсэн зүйлүүдийг тарималжуулахад аж ахуйн нэгжтэй хамтран ажиллаж эхлээд байна.

- Харь зүйлийн эрсдэлийн үнэлгээ, хяналтын механизмыг бүрдүүлэх ажлын хүрээнд бэлтгэл ажил хийгдэж байна.

2.5 Генетик нөөц, түүнтэй холбогдох уламжлалт мэдлэгийг бүртгэж үнэлэх, ашиглах эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлж, нөөцийн үр өгөөжийг хүртэх нөхцөлийг хангах арга замын хүрээнд:

- Генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашигласнаас бий болох үр өгөөжийг хүртээх тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэг байгуулан ажиллаж, холбогдох хэлэлцүүлэг, судалгааг хийж, хуулийн төслийг эцэслэн боловсруулж байна.

- БОАЖЯ-ны зүгээс Даян дэлхийн байгаль орчны сан /GEF/-тай хамтран “Генийн нөөцийн Нагоягийн протоколийг хэрэгжүүлэхэд эрх зүй, байгууллага, хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх нь” төслийг хэрэгжүүлж эхлээд байна.

2.6 Хувиргасан амьд организмын хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд үзүүлэх эрсдэлийг үнэлж, урьдчилан сэргийлэх чадавхыг бэхжүүлж, импорт, худалдааны хязгаарлалт тогтоох арга замын хүрээнд:

- Үйлдвэрлэлийн зориулалт бүхий өндөр бүтээмжтэй мод үржүүлгийн аж ахуй эрхлэх ажлыг дэмжиж 2017 онд Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутагт үйлдвэрлэлийн зориулалтаар плантаци байгуулах ажлыг 5 га талбайд эхлүүлсэн.

- Байгаль Орчин Ногоон Хөгжлийн Сайд/хуучнаар/-ын 2013 оны 04 дүгээр сарын 30-ны А-132 тоот тушаалаар Төмөр замын дэр мод үйлдвэрлэх зорилгоор ойгоос мод бэлтгэхийг 2013 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 5 жилийн хугацаатай хориглосон. Энэхүү тушаалд БОАЖС-ын 2017 оны тушаалаар нэмэлт өөрчлөлт оруулж, 2018 оны 05 дугаар 01-ний өдрөөс эхлэн галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдалд мөрдөх техникийн нөхцөлөөр төмөр бетон дэр ашиглахыг хориглосноос бусад хэсэгт модон дэр ашиглахыг бүрмөсөн хориглосон. Ойн тухай хуулиар барилгын хэв хашмал тулаасанд бөөрөнхий мод ашиглахыг хориглосон.

2.8 Ой, түүний дагалт баялаг, байгалийн ургамал, амьтны хамгаалалт, зохистой ашиглалтад нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн менежментийг төлөвшүүлж, тогтвортой санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх арга замын хүрээнд:

- 2016 онд 7 аймгийн 42 сумын 101 аж ахуйн нэгж, байгууллага, 126 ойн нөхөрлөлийн 1454 иргэн хөтөлбөрт хамрагдан 377 иргэн түр болон байнгын ажлын байраар хангагдсан байна. Одоогоор улсын хэмжээнд байгалийн нөөцийн хамтын менежментийн 1629 нөхөрлөл 41.3 мянган гишүүнтэйгээр 8.2 сая га талбайг хариуцан хамгаалж, үйл ажиллагаа явуулж байна. Тэдгээрийн 1281 нөхөрлөл нь 3.3 сая га талбай бүхий ойн санг гэрээгээр эзэмшиж, нийт 6742 өрхийн 23496 гишүүн хамрагдаж байна.

- БОАЖЯ санаачлан өөрийн болон олон улсын төсөл хөтөлбөрүүдийн санхүүгийн дэмжлэгтэйгээр дэмжлэгтэйгээр Байгаль хамгаалах нөхөрлөлүүдийн үндэсний холбоотой хамтран 2015, 2017 онуудад Байгаль хамгаалах нөхөрлөлүүдийн Үндэсний чуулганыг Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор зохион байгууллаа. Чуулганаар нөхөрлөлүүдийг дэмжих бодлого, түүний эрх зүйн орчин, тулгамдсан асуудлуудыг тодорхойлж удирдлагаар хангах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, чадавхижуулах ажлуудыг тодорхойлсон.

- "Байгаль орчныг хамгаалах тухай" хуульд нөхөрлөлийн асуудлаар өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, үзэл баримтлалыг боловсруулж УИХ-д өргөн барихад бэлэн болгосон. Уг хуулийн 1-р зүйлийн 1-7, 2-р зүйлийн 1-3 дахь заалтад нэмэлт, өөрчлөлт оруулснаар нөхөрлөлүүд, гэрчилгээ тамгатай санхүүгийн хувьд бие даасан "хуулийн этгээд" болж, менежментийн төлөвлөгөөг батлуулан, байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос санхүүжүүлэх бололцоотой болох юм. 2016 оны 11-р сарын 15-ны өдөр БОАЖЯ, Байгаль хамгаалах ногоон хөгжлийн нөхөрлөлүүдийн Үндэсний холбоо /БХНҮХ/ хооронд "Хамтын ажиллагааны гэрээ" байгуулагдсан. Энэхүү гэрээ батлагдсанаар нөхөрлөлүүдийн холбооны төлөөлөл сайдын зөвлөлд ажиллах, тендерийн хороонд төлөөлөл оролцуулах, үндэсний хэмжээний сүлжээг байгуулж салбарын хэмжээнд олон улсын сургалтанд хамрагдах боломжтой боллоо. НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас Булган, Сэлэнгэ, Дархан Уул, Хэнтий, Хөвсгөл зэрэг аймгуудын 101 нөхөрлөлд 3 болон 10 жилийн хугацаатай "Ойн менежментийн төлөвлөгөө" боловсруулж түүнийгээ хэрэгжүүлэхэд нь арга зүйн зөвлөгөө өгч холбогдох дэмжлэг үзүүлсэн.

- Сумын төвийн шинэчлэл төслийн хүрээнд 9 аймгийн 9 суманд, Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн хүрээнд 6 аймгийн 8 суманд инженерийн шугам сүлжээг шинээр барьж ашиглалтад оруулсан.

- Усан сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журмыг БОНХАЖ-ын сайд, Барилга, хот байгуулалтын сайдын хамтарсан 2015 оны А-230/127 дугаар тушаалаар батлуулан хэрэгжүүлж байна.

- Улаанбаатар хотын ус хангамжийн эх үүсвэрүүдийн усны нөөцийг дахин үнэлэх ажил хийгдсэн. Үүний мөрөөр нийслэлийн ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүс, тэжээгдлийн мужийг тогтоож, БХБЯ, Нийслэлийн хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газарт хүргүүлсэн. БХБ-ын сайд, БОАЖ-ын сайдын хамтарсан нийслэлийн ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүс, тэжээгдлийн мужийн заагийг тогтоох тушаалын төслийг боловсруулж БХБЯ-нд хүргүүлсэн. 2017 оны 02 дугаар сард Нийслэлийн ИТХ-д Улаанбаатар хотын ус хангамжийн төвлөрсөн эх үүсвэрийн хамгаалалтын бүсэд хийсэн дүгнэлтийг хүргүүлсэн.

2.10 Үйлдвэрлэлийн зориулалтаар газрын доорх цэнгээг усны ашиглалтыг хязгаарлан, хаягдал усыг стандартын түвшинд хүртэл цэвэрлэж дахин ашиглах, эргүүлэн ашиглах технологи нэвтрүүлэхийг дэмжих арга замын хүрээнд:

- “Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль” хэрэгжиж эхлэхэд учирч болох хүндрэл бэрхшээлүүдийг тооцоолон судалж, тэдгээрийг шийдвэрлэх арга замыг тодорхой болгох, хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээг бууруулж байгаа аж ахуйн нэгжүүдийг дэмжих бодлогод тулгуурлан хаягдал усны эрх зүйн орчныг боловсронгуй болгохоор ажиллаж байна. Одоогоор Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, үзэл баримтлал, холбогдох 4 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг эцэслэн боловсруулсан. Энэхүү хуулийн төслийг УИХ-ын 2017 оны хаврын чуулганд өргөн барихаар төлөвлөж байгаа бөгөөд хууль батлагдсанаар хаягдал усыг эргүүлэн ашиглах хэрэгцээ шаардлагыг нэмэгдүүлэх эрх зүйн таатай орчныг бий болно.

- “Гаалийн албан татвараас чөлөөлөгдөх жижиг, дунд үйлдвэрийн зориулалт бүхий тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн жагсаалт батлах тухай” Засгийн газрын тогтоолын төсөлд бохир ус цэвэрлэх тоног төхөөрөмж зэрэг нийт 24 тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн саналыг ХХААХҮЯ, СЯ-нд хүргүүлсэн. Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, усны нөөцийг хамгаалах, зүй зохистой, эргүүлэн ашиглах технологийг нэвтрүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ААН-үүдийг дэмжих зорилгоор “Усыг хэмнэлттэй ашиглах, хамгаалах-техник, технологи” үзэсгэлэнг 2017 оны 3 дугаар сарын 22-ны өдөр МҮХАҮТ-тай хамтран зохион байгуулсан.

- УИХ-ын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос 2016 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр зохион байгуулсан “Төв цэвэрлэх байгууламжийн өнөөгийн байдал, хөрөнгө оруулалтын асуудал” сэдэвт хэлэлцүүлгээс гарсан зөвлөмжийн дагуу шинээр барих цэвэрлэх байгууламжийн зураг төсөл, ТЭЗҮ-д үнэлэлт, дүгнэлт өгч, хөрөнгө оруулалт, технологийг судлах үүрэг бүхий ажлын хэсгийг Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 191 тоот тушаалаар байгуулсан. Уг ажлын хэсэг лагийг дахин боловсруулах шаардлагыг төв цэвэрлэх байгууламжийн ТЭЗҮ-д тусгуулан

- Улсын тусгай хэрэгцээний аймаг дундын отрын 9 бүс нутагт 783.3 мянган га, орон нутгийн тусгай хэрэгцээнд 5.4 сая га бэлчээрийг авч ашиглаж байна. "Монгол мал" хөтөлбөрт нийт бэлчээрийн 10 хүртэл хувийг улсын болон орон нутгийн тусгай хэрэгцээнд авахаар тусгасны дагуу тусгай хэрэгцээний бэлчээрийн газрыг нэмэгдүүлэх, бэлчээрийг сэлгэн өнжөөж ашиглан, доройтсон бэлчээрийг сайжруулах асуудал тусгагдсан.

- Малчдаас бэлчээр ашигласны төлбөрийг малын төрөл, бэлчээрийн төлөв байдлаар нь ялгавартай тогтоож авах эрх зүйн орчныг боловсронгуй болгох ажлыг төлөвлөн ажиллаж байна.

- Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын хүрээнд Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Сайншанд, Хөөт-Бичигт, Хөөт-Чойбалсан чиглэлд баригдах төмөр замын төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний ажил хийгдэж, төмөр замын зурвас газрын дагуу цөлжилтөд хүчтэй өртөж байгаа газар нутагт цөлжилтийг сааруулах мод, ойн зурвас байгуулах, төлөвлөн хэрэгжүүлэх ажлыг эхлүүлэх боломжтой болно.

2.13 Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон, бохирдолд өртсөн, атаршсан газрын 70-аас доошгүй хувийг нөхөн сэргээж аж ахуйн зориулалтаар дахин ашиглахад чиглэсэн үйл ажиллагааг дэмжих арга замын хүрээнд:

- Эвдэрсэн газрын тооллогын дүнгээс үзэхэд 2012 оны эцсийн байдлаар 20 аймгийн нутаг дэвсгэрийг хамарсан 699 нэгж талбар бүхий 4256 га эвдэрсэн талбай нөхөн сэргээлт хийгдээгүй, хариуцах эзэнгүй орхигдсон байна. 2016 оны байдлаар, уул уурхайн үйл ажиллагаанаас 27068.0 га талбай эвдрэлд орсноос 11375 га-д буюу 42.02%-д техникийн нөхөн сэргээлт, 7425.0 га-д буюу 27.4%-д биологийн нөхөн сэргээлтийг тус тус хийсэн байна. Нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд 2016 оны байдлаар 11.3 тэрбум төгрөгийг байршуулсан байна. БОАЖ-ын сайдын 2017 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн а/71 тоот тушаалаар "Уул уурхайн ашиглалтын улмаас эвдэрсэн газрын тооллого хийх ажлын удирдамж", Эвдэрсэн газрын тооллогын судалгааны хүснэгтийг баталсан. 2017 онд 5 аймагт эвдэрсэн газрын тооллого хийнэ.

- НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн "Монголын уул уурхайн салбарт хэрэгжиж буй байгаль орчны хууль тогтоомж дахь эрх зүйт ёсны зарчмын үнэлгээ төсөл"-ийн дэмжлэгтэйгээр "Архангай аймгийн Цэнхэр сумын Орхон багийн нутагт орших Монгол газар, Эм жи эйч ХХК-иудын өөрийн эзэмшлийн талбайг аж ахуйн нэгж байгууллагуудад түрээсэлснээс үүдсэн байгаль орчинд учруулсан хохирлын тайлан"-г боловсруулсан.

2.14. Байгалийн баялгийг зохистой ашиглах эрх зүйн зохицуулалт, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг сайжруулах механизмыг боловсронгуй болгох арга замын хүрээнд:

- Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-ыг батлуулсан.

- Засгийн газар, орон нутаг, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн ажлын уялдаа холбоог сайжруулах, талуудын оролцоог хангах, дэмжих асуудлыг шийдвэрлэх үүднээс Уул уурхайн яам, Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэгийн Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүхэн санаачлага хөтөлбөр, Монголын тогтвортой хөгжил, нийгмийн хариуцлагын зөвлөлтөй хамтран "Орон

бүрийг тоолууржуулах шаардлага тавьж, эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан усны тоолуур суурилуулах, усны нөөц ашигласны төлбөрийг усны тоолуурын заалтаар тооцож байх даалгаврыг хүргүүлэн хэрэгжилтэнд нь хяналт тавьсанаар 2016 оны байдлаар улсын хэмжээнд ус хэрэглэгчдийн 82.3%, ус ашиглагчдийн 37,1% - нь усны тоолуур суурилуулсан байна.

- 2016 онд ус хэрэглэгч, ашиглагчдын Ус хэрэглээний нормыг шинэчлэн боловсруулж батлуулан ус ашигласны төлбөрийг тооцоход ашиглаж байна.

- Ус хэрэглэгч, ашиглагчдыг тоолууржуулах чиглэлээр Дундговь, Сүхбаатар, Увс, Баян-Өлгий аймаг тодорхой ажлуудыг хийж зохих үр дүнд хүрсэн байна.

3.2. Байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэл, хэрэглээний дадлыг төлөвшүүлэх, дэмжих, байгалийн нөөцийн ашиглалтын бүтээмжийг нэмэгдүүлэх эдийн засгийн хөшүүргийг бүрдүүлэх арга замын хүрээнд:

- “Байгаль орчинд ээлтэй технологи нэвтрүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах журам”, “Байгаль орчны эко тэмдэг олгох” журмын төслийг боловсруулан нөлөөллийн шинжилгээ хийж олон нийтийн санал авах хэлэлцүүлэг зохион байгуулж байна.

- НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрөөс гаргасан тогтвортой хэрэглээ, үйлдвэрлэлийн бодлого, зарчмыг хэрэгжүүлэх талаар судалгаа хийх, манай улсад нэвтрүүлж нутагшуулах арга замыг тодорхойлох баримт бичгийн төслийг боловсруулахад хандивлагч орнууд, олон улсын байгууллагуудаас дэмжлэг авах чиглэлээр санал боловсруулж хандаад байна.

- Байгальд ээлтэй техник технологийн үзэсгэлэн худалдааг жил бүр зохион байгуулж, гадаад, дотоод зах зээлд сурталчлах талаар арга хэмжээ авч байна. “Ногоон технологи, инноваци-2016” зөвлөгөөн, үзэсгэлэнг нарны эрчим хүч, эрчим хүчний хэмнэлттэй уурын бойлер, зуух, халаалтын тоног төхөөрөмж, лэд гэрэл, дулааны алдагдал багатай, байгаль орчинд ээлтэй барилгын материал, усны хэмнэлттэй болон бохир ус цэвэрлэх технологи, биобордоо, биотүлшний үйлдвэрлэл, худалдаа эрхэлдэг байгууллага зэрэг нийт 60 гаруй аж ахуйн нэгж байгууллага, эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдийг хамруулан зохион байгуулсан. Үзэсгэлэнд оролцсон аж ахуйн нэгжүүдээс шилдэг ногоон технологи, бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа аж ахуйн нэгжийг шалгаруулан өргөмжлөл, мөнгөн шагнал олгосон болно.

- “Агаарын бохирдлыг бууруулахад иргэн таны оролцоо” сарын аяны хүрээнд агаарын бохирдлыг бууруулах, эрчим хүчний хэмнэлттэй, байгальд ээлтэй техник, технологийн үзэсгэлэн, худалдааг НЗДТГ-тай хамтран зохион байгуулсан. Үзэсгэлэн худалдаанд нийт 50 гаруй аж ахуйн нэгж байгууллага оролцон өөрийн үйлдвэрлэж болон худалдаалж буй техник тоног төхөөрөмжөө иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад сурталчиллаа.

- БОАЖЯ, Монголын Банкны Холбоо, Ногоон эдийн засгийн төлөөх түншлэл, Даян дэлхийн ногоон хөгжлийн байгууллага, Тогтвортой хөгжлийн боловсрол төсөл зэрэг байгууллагуудын хамтарсан Ногоон зээлийн сангийн ажлын хэсгийг байгуулж, зээлийн сангийн ажлын хэсгийн үйл ажиллагааны журам, ажлын төлөвлөгөөг баталсан. Ажлын хэсгийн хүрээнд ногоон зээлийн сангийн үзэл баримтлал, зах зээлийн судалгаа, ногоон зээлийн шалгуур үзүүлэлт, хууль эрх зүйн зүйн үндэслэлийн судалгааны ажлуудыг гүйцэтгэн, 2016 оны 11 дүгээр сард зохион байгуулагдсан ТоС-2016 форумын үеэр хэлэлцүүлж, урьдчилсан шийдэл гаргасан.

бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, тендерийн жишиг баримт бичгүүд, холбогдох журамд нэмэлт, өөрчлөлт хийх ажлыг Азийн хөгжлийн банкны төслийн хүрээнд хийж байна

3.6 Засгийн газрын худалдан авалтын 20-иос доошгүй хувийг байгаль орчинд ээлтэй, үр ашигтай, хэмнэлттэй бараа, ажил, үйлчилгээ авахад зарцуулах арга замын хүрээнд:

- Засгийн газрын тогтвортой/ногоон худалдан авалтыг хэрэгжүүлэх бодлогын судалгаа хийж дуусган тайланг нь НҮББОХ-ын албан ёсны вебсайт дээр нийтэлж олон нийтэд танилцуулсан.

- Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр худалдан авч буй бараа бүтээгдэхүүний судалгааг хийж бичгийн цаас, принтерийн хор, хөнгөн блок гэсэн 3 бүтээгдэхүүнийг ногоон бүтээгдэхүүнээр солих боломж, зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн байгальд ээлтэй бараа, бүтээгдэхүүнээр орлуулах боломжийг тодорхойлсон.

- БОАЖЯ-с 2016 оны 10,11-р сард зохион байгуулсан “Ногоон хөгжлийн төлөө хамтдаа” сарын аяны хүрээнд “Ногоон оффис”-ын зарчмуудыг хэрэгжүүлэх, анхан шатны судалгаа гаргах ажлуудыг хийсэн. Хаягдал цаас боловсруулж ашигладаг үйлдвэрийн судалгаа хийж яамнаас гарч буй хаягдал цаас цуглуулах ажлыг зохион байгуулан ВIV ХХК-ны “Сайхан арвин” ариун цэврийн цаасны үйлдвэрт сард 2 удаа тогтмол нийлүүлэх талаар гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. Эко клубт хамаарагддаг 6 сургуулийн хүүхдүүдээр Байгаль орчин аялал жуулчлалын яамны ажлын байранд “Ногоон офиссын үнэлгээ”-г цахилгаан, дулаан, усны хэрэглээ, ажлын байрны гадаад, дотоод орчин гэсэн сэдвээр хийлгэн дүгнэлт гаргасан тухай мэдээллийг цахим хуудсанд байршуулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна.

3.7 Банк санхүүгийн байгууллагын байгаль орчинд ээлтэй тогтвортой санхүүжилтийн тогтолцоог бий болгож, аж ахуйн нэгж, байгууллагын нийгмийн хариуцлагыг өндөржүүлэх арга замын хүрээнд:

- Монголын Банкны Холбоо /МБХ/-ноос санаачилсан Тогтвортой санхүүжилтийн хөтөлбөр /ТоС/-ийг бодлогоор дэмжин, тогтвортой санхүүжилтийн 8 зарчмыг боловсруулахад арга зүйн зөвлөмж өгч БОАЖЯ, Монголбанк, НЗДТГ, МБХ хооронд 4 талт санамж бичгийг байгуулан хэрэгжүүлж ТоС-ийн зарчмуудыг нийт арилжааны банкууд үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн. Тогтвортой санхүүжилтийн зарчмыг бусад санхүүгийн системд нэвтрүүлэх судалгааг НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр, Монгол Банкны холбоотой хамтран хийх төслийн ажлыг эхлүүлэх бэлтгэлийг хангаж байна.

- Монголын Банкны Холбоо, Даян дэлхийн ногоон хөгжлийн байгууллага, Олон улсын санхүүгийн корпораци, Ногоон эдийн засгийн төлөөх түншлэл, Тогтвортой хөгжлийн боловсрол төсөл зэрэг дотоодын болон олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр Ногоон зээлийн сангийн зах зээлийн эрэлт, эрх зүйн орчин, ногоон зээлийн шалгуур үзүүлэлтийн харьцуулсан судалгаа, НЗС-ийн ерөнхий үзэл баримтлал, бизнес загвар, бизнес төлөвлөгөө зэрэг судалгааны ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Ногоон зээлийн сантай холбогдох асуудлын тухай Засгийн газрын шийдвэрийн төслийг ЗГХЭГ-т хүргүүлэхээр ажиллаж байна.

3.8. Ногоон хөгжлийн үзүүлэлтийг Үндэсний тооцооны системд тусган байгаль орчноос нийгэм, эдийн засгийн хөгжилд оруулах хувь нэмрийг тооцоох арга замын хүрээнд:

СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 4: Ногоон ажил эрхлэлтийг дэмжих, ядуурлыг бууруулан ногоон амьдралын хэв маягийг төлөвшүүлнэ.

4.1. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байнгын ажлын байрыг нэмэгдүүлж, хөдөлмөрийн насны хүн амын 80-аас дээш хувь нь зохистой хөдөлмөр эрхэлж, баталгаатай орлоготой болох нөхцөлийг бүрдүүлэх;

Стратегийн гуравдугаар зорилтыг 7 арга замаар нийт 36 үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэхээр тусгагдсан.

- 2016 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн Засгийн газрын 320 дугаар тогтоолоор "Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого"-ыг батлаж, түүнд зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж ядуурлын түвшинг бууруулна гэж заасан.

- Үндэсний статистикийн хороо нь Олон улсын хөдөлмөрийн байгууллага, ногоон эдийн засгийн төлөөх түншлэл төслийн хүрээнд ногоон ажлын байрыг тодорхойлох туршилт судалгааг өрхөд суурилсан ажиллах хүчний 2014 оны 4-р улирал, 2016 оны 1, 2 дугаар улирлын судалгаа болон аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны 2014 оны жилийн судалгаанд нэмэлт модуль хэлбэрээр хавсаргаж явуулсан. Судалгаанд нийт 9612 өрхийн 26214 гишүүдийг хамруулсан. Ногоон ажлын байрны статистик мэдээлэл нь ногоон эдийн засагт шилжихэд бий болох ажлын байрны цар хүрээ, тухайн салбарт шаардлагатай мэргэжилтэй ажилтанг бэлтгэх, мэдлэг ур чадварыг дээшлүүлэхтэй холбоотой бодлого, шийдвэрийг боловсруулж, хэрэгжүүлэхэд хэрэгтэй тул 2017 оноос ногоон ажлын байрны судалгааг тогтмол давтамжтай явуулахаар болсон. Ногоон ажлын байрны бодит жишээнээс дурьдвал: Эрчим хүчний хэмнэлттэй гэрэлтүүлгийн үйлдвэр 2014 онд ашиглалтад орсноор 20 орчим ногоон ажлын байр шинээр болсон. Жилд 37.0 сая кВт цаг цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх хүчин чадалтай Тайширын усан цахилгаан станц нь 25-30 ногоон ажлын байрыг, Салхитын салхин цахилгаан станц нь 29-30 ногоон ажлын байрыг тус тус бий болгосон. Мөн хариуцлагатай уул уурхайн үйл ажиллагаа эрчимжиж, нөхөн сэргээлтийн арга туршлагыг амьдралд бодитойгоор хэрэгжүүлж байна.

- Иргэдэд хөдөлмөр эрхлэлтийн ур чадварыг эзэмшүүлж, хөдөлмөрийн зах зээлд бэлтгэх, ажлын байрыг дэмжиж, ажил олгогчид урамшуулал үзүүлэх хөтөлбөрийн хүрээнд ногоон ажлын байр болон бусад ажлын байр бий болгосон ажил олгогчийг дэмжих арга хэмжээнд 137 ажил олгогч, 206 иргэн хамрагдсан. Үүнд: 1/ Урамшуулалд 187 иргэнийг ажлын байраар хангасан 120 ажил олгогчид 434,133.5 сая төгрөгийг зарцуулсан. 2/ Санхүүгийн дэмжлэгт 19 иргэнийг ажлын байраар хангасан, 17 ажил олгогчид 67,656.0 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус зарцуулсан. 2016 онд 228 иргэнийг шинээр ажлын байраар хангахаар гэрээ байгуулан ажиллаж байна.

- Европын холбооны санхүүжилттэйгээр хэрэгжиж буй "Монгол Улсын Техник, Мэргэжлийн боловсрол, сургалтын салбарыг дэмжих төсөл"-ийн хүрээнд 2015 онд Техник мэргэжлийн боловсрол, сургалтын хөгжлийн ассоциаци, Мэргэжлийн боловсрол сургалтын түншлэл төрийн бус байгууллага хамтран "Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төрөлжилт, чанар, үр дүн" судалгааны ажлыг гүйцэтгэсэн.

- Азийн хөгжлийн банкны 3243 дугаар зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй "Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх" төслийн хүрээнд "Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг төрөлжүүлэн хөгжүүлэх үндсэн чиглэлийг

4.3. Амьжиргааны олон талт эх үүсвэрийг бий болгон, нийгмийн хамгааллын суурийг өргөжүүлэх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, дундаж давхаргыг бэхжүүлэх;

- Ажлын байранд суурилсан цалин хөлсний тогтолцоо нэвтрүүлэх нарийвчилсан төлөвлөгөөний дагуу Эрүүл мэндийн салбарын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн ажлын байранд үнэлгээ хийх аргачлал боловсруулсан.

- Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр болон Монголбанкны баримталж буй үндэсний хуримтлалын бодлогын хүрээнд Голомт банкны санаачлан хэрэгжүүлж буй “Үндэсний хуримтлалын хөтөлбөр”-ийг 2015 оны 11-р сарын 2-ны өдөр албан ёсоор нээсэн. Ийнхүү айл өрх, улс орон маань үндэсний хуримтлалтай болсноор эдийн засгийн хямралд өртөх эрсдэлээс сэргийлж, мөнгөн урсгалыг дотооддоо хадгалж, эдийн засгийн өсөлтөд урт хугацаанд эерэгээр нөлөөлнө.

- Иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлж, хувийн хуримтлалыг бий болгох зорилгоор 2015 оны 6-р сарын 23-нд “Тогтвортой санхүүжилтийн сургагч багшийн сургалт-2”-ийг Монголын Банкны Холбоо, Олон улсын санхүүгийн корпораци болон Банк санхүүгийн академиас хамтран Тогтвортой санхүүжилтийн гишүүн банкуудын төлөөлөл болон Тогтвортой санхүүжилтийн хөтөлбөрт хамтарч ажиллахаар шалгарсан зөвлөхүүдэд заасан.

- 2016 оны 4-р сарын 25-нд Олон Улсын санхүүгийн корпораци, Монгол банк болон Монголын Банкны Холбоо хамтран “Үнийн цэнийн сүлжээг санхүүжүүлэх нь сургалт, семинарыг нийт 90 гаруй хүнийг хамруулан зохион байгуулсан.

- 2016 онд Аж ахуй эрхлэх, бичил бизнесийг дэмжих, Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 11100 иргэнийг хамруулж, 6473248.1 мян.төгрөгийг зарцуулж 3852 ажлын байрыг бий болгосон. Мөн бичил бизнес эрхлэгч 1021 иргэнд 4,114,476.4 мян.төгрөгийн жижиг зээлийг олгож 1021 иргэний ажлын байр хадгалагдаж шинээр бий болсон. 2017 онд “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийг Засгийн газраар, “Аж ахуй эрхлэх, ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийг Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөр тус тус батлуулан хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2017 оны төсөв 61,5 тэрбум төгрөгөөр батлагдсан ба малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл хоршоо байгуулах иргэн, аж ахуйн нэгж байгууллагад олгох жижиг зээлэнд 32,5 хувийг хөтөлбөр, арга хэмжээнд 40,9 хувийг, зарцуулж байгаа нь өмнөх онтой харьцуулахад жижиг зээл 6,6 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулах хөрөнгө 3,6 хувиар нэмэгдсэн байна. Өрхийн болон бичил бизнес эрхлэгч иргэдэд жижиг зээл олгох болон эдийн засгийн хямралтай үед иргэдийг түр ажлын байраар хангах зорилтын хүрээнд 15,750 иргэнийг түр ажлын байраар, 6160 иргэнийг байнгын ажлын байраар, нийт 25,720 иргэнийг ажлын байраар хангахаар төлөвлөн ажиллаж байна.

- Өнөөдрийн байдлаар нийт 153,000 гаруй малчин өрхийн 47,6 хувь нь 101-200 толгой малтай, ихэнх нь сарын дундаж орлого нь амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур байна. Иймд малчин өрхийн орлогыг нэмэгдүүлэх, түүхий эдийн үнийн тогтвортой байдлыг хангах, сүү сүүн бүтээгдэхүүний зах зээл болон эрэлтийг нэмэгдүүлэх, гэрийн нөхцөлд сүүн бүтээгдэхүүн, ноос ноосон бүтээгдэхүүн, арьс шир болон туслах аж ахуйн техникийн туслалцааг жил бүр өссөн дүнгээр нэмэгдүүлж малчдыг дэмжиж байхаар төлөвлөн ажиллаж байна.

стандарт буюу заавал мөрдөх 379, зөвлөмжит 374 стандартыг тус тус мөрдөн ажиллаж байна.

- Хөдөө аж ахуйн, эрүүл ахуйн, үйлдвэрлэлийн зохистой дадлыг хялбаршуулан нэвтрүүлэх зааврын төслийг боловсруулаад байна. Тус заавар хэрэгжсэнээр хүнс, хөдөө аж ахуйн салбарт зохистой дадлыг хэвшүүлэх, үйлдвэрийн бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйд ахиц гарах болно.

- Монгол Улсын хэмжээнд хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны стандарт нэвтрүүлсэн 4 үйлдвэр ажилладаг. Цаашид энэ чиглэлээр аж ахуйн нэгжүүдэд дэмжлэг үзүүлэх арга механизмыг судалж байна. Баяжуулагч бэлдмэл, хүнсний нэмэлт, өсгөврийн хөрөнгө, органик болон шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсийг бүртгэх журмын төслийг боловсруулаад байна. "Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль"-ийн хүрээнд хүнсний сүлжээнд, хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчид бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг сүлжээний тухайн шатанд өөрөө хариуцахаар тусгагдсан. Хувийн хэвшлийн санаачилгыг дэмжин ажиллаж байна. Тухайлбал: "Номинтав" ХХК-ийн зүгээс эко бүтээгдэхүүнийг худалдаалах орчин, нөхцлийг бүрдүүлсэн байна.

- Хүнс, хөдөө, аж ахуйн сайдын 2016 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А-71 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг "Баяжуулсан хүнсний тухай хууль"-ийн төслийг боловсруулан 2 удаа хэлэлцүүлэг зохион байгуулж, 2017 онд хуулийн төслийг УИХ-д өргөн барьсан байна. "Баяжуулагч бэлдмэл, хүнсний нэмэлт, өсгөврийн хөрөнгө, органик болон шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсийг Улсын бүртгэлд бүртгэх, нийтийн хэрэгцээнд гаргах" журмын төслийг боловсруулаад байна.

- Эрүүл мэндийн Сайдын 2013 оны 13-р тушаалаар "Биологийн идэвхит бүтээгдэхүүний бүртгэл"-ийн журам батлагдаж, 2016 оны байдлаар 210 нэрийн импорт, 8 нэрийн үндэсний бүтээгдэхүүнийг улсын бүртгэлд бүртгэж гэрчилгээ олгоод байна. Хувиргасан амьд организмгаас гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний эрсдэлийг үнэлэх журмын төслийг боловсруулаад байна.

- Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт "Мах, сүүний анхдугаар аян зохион, хүн амыг эрүүл, аюулгүй бүтээгдэхүүнээр хангана" гэсэн зорилтын хүрээнд 2017 оны 1-р сарын 1-ний өдрөөс "Мах, сүүний анхдугаар аян"-ыг улсын хэмжээнд өрнүүлэхээр шийдвэрлэлээ. Аяныг "Эрүүл хүнс-Эрүүл монгол хүн" уриан дор зохион байгуулах бөгөөд хөдөө аж ахуйн боломжит нөөцөө бүрэн ашиглах, өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх, иргэдээ баталгаат хүнсээр, үйлдвэрээ түүхий эдээр тогтвортой хангаж, улмаар эдийн засагт тодорхой өсөлт гарах болно.

- 2016 онд батлагдан 2017 оны 1-р сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэгжиж байгаа "Органик хүнсний тухай хууль"-ийг дагалдан гарах "Органик мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэхэд баримтлах журам", "Органик газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэхэд баримтлах журам", "Органик зөгийн аж ахуй эрхлэхэд баримтлах журам"-ын төслийг боловсруулж цахим хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Хөрсний үржил шим, бүтцийг сайжруулах, ургамал хамгаалах ба ургамлын өсөлт идэвхжүүлэх, Мал аж ахуйн үйлдвэрлэлд хэрэглэхийг зөвшөөрсөн, органик хүнс боловсруулахад ашиглах хүнсний нэмэлт болон туслах бодис, тоног төхөөрөмж, малын байр, хашаа саравч, тоног төхөөрөмжийн ариутгал, халдваргүйжүүлэлт болон шавж устгалд хэрэглэх бодисын жагсаалтын төслийг тус тус боловсруулаад байна.

75,000 ам.доллар, Рэнчинлхүмбэд 75,000 ам.доллар буюу төслийн нийт санхүүжилтийн 17 хувь болох 520,000 ам.долларын эргэлтийн сан байгуулан иргэдийн орлогыг нэмэгдүүлж, амьжиргааг сайжруулахад зарцуулахаар төлөвлөсөн. 4/ “Гамшигийн эрсдлийг бууруулах менежмент, зохицуулалтын чадавхийг сайжруулах” төсөл, МУ-ын Засгийн газар болон ГОУХАН-ийн хамтын ажиллагааны хүрээнд “Уур амьсгалын өөрчлөлтөд ойн гол экосистемүүдийн дасан зохицох нь” зэрэг төслүүд байна.

- Байгалийн нөөцийн хамтын менежментийг дэмжиж, ойн цэвэрлэгээ, цөлжилтөөс сэргийлэх, нөхөн сэргээх үйл ажиллагаанд орон нутгийн иргэдийг татан оролцуулахад чиглүүлэн Ойн цэвэрлэгээ хөтөлбөр хэрэгжиж буй Хөвсгөл, Булган, Сэлэнгэ, Төв аймгийн 10 сумдын ойн нөхөрлөл, ойн мэргэжлийн байгууллагын нийт 343 ажилчдыг мэргэжилтэй ажилтан бэлтгэх түр сургалтад хамруулсан. Мөн Сэлэнгэ аймгийн Мандал сумын Түнхэл баг, Төв аймгийн Мөнгөнморьт зэрэг 5 сумдын удирдлагууд болон ойн нөхөрлөл, мэргэжлийн байгууллагын ажилчдыг ойн цэвэрлэгээнд ашиглах техник, тоног төхөөрөмжийг сурталчлан танилцуулах, үзүүлэх сургалтад хамруулсан.

- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд орон нутгийн иргэдийг татан оролцуулж, ногоон ажлын байр, түр ажлын байраар хангах зорилгоор Сэлэнгэ аймаг нь ойжуулалт, мод үржүүлгийн ажилд 500 гаруй мод бэлтгэх, боловсруулах ажилд 100 гаруй хүнийг ажилуулсан байна.

- 2016 оны 12-р сарын 04-05-ны өдрүүдэд “Хөгжлийн бодлого төлөвлөлтөд дасан зохицохуйг тусгах нь” сургалтыг Баянхонгор аймгийн удирдлага, Гамшгийн олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгтэй хамтран Хүнс, хөдөө аж ахуйн газар, Цаг уур, орчны шинжилгээний алба, Эрүүл мэндийн газруудын мэргэжилтнүүд болон сумдын Засаг дарга, байгаль хамгаалагч зэрэг 45 хүнийг хамруулан зохион байгуулж гэрчилгээ олгосон. Цаашид энэхүү сургалтыг сумдад зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

- Ойн ангийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалтыг 2017 оны 2-р сарын 14-20-ны өдрүүдэд Монгол Улсын 21 аймгийн Байгаль орчны газрын ойн нэгж, 40 сумын сум дундын болоод сумын ойн ангийн инженер, техникч, мэргэжилтнүүдийг оролцуулан нийт 76 хүнийг сургалтад хамруулан зохион байгуулсан.

4.7. Алслагдсан нутагт бэлчээрийн даацад тохируулан мал аж ахуй эрхэлж, усны эх, булаг, шандыг арчилж тордох зэргээр бэлчээрийн доройтлоос сэргийлэх чиглэлээр санаачилгатай ажиллаж байгаа малчдад экосистемийн үйлчилгээний төлбөрийн урамшуулал олгох механизмыг бүрдүүлэх;

- 2016 онд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр нийт 152 булаг, шандны эхийг хашиж, хамгаалаад байна. Тухайлбал: Булган аймгийн Могод сумын Хулжийн халуун рашаан, Дорнод аймгийн Матад сумын Нарангийн рашаан, Баяндун сумын Угтамын рашаан зэрэг болно. Сүхбаатар аймгийн Дарьганга сумын нутаг дахь Ганга нуурын эргийн дагуу 6.7км, Булган аймгийн Дашинчилэн сумын нутаг дахь Чулуут нуурын эргэн тойрны 9 га талбайг гадаргын усны нөөцийг хамгаалах зорилгоор хашиж хамгаалсан.

- Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр Архангай аймгийн Чулуут сумын Ихэр булаг, Их тамир сумын Байтын харзыг түшиглэн 2 хөв, Говь-Алтай аймгийн Төгрөг, Цогт, Алтай, Цээл сумдад тус бүр нэг хөвийг газрын

туршийн боловсролын төвийн багш нарыг энэ чиглэлээр чадавхжуулах сургалтыг 2 үе шаттайгаар зохион байгуулан 560 гаруй багш нарыг хамруулав.

- Олон нийт, сэтгүүлчид, байгаль орчны салбарын мэргэжилтнүүдэд зориулсан гарын авлагыг шинэчлэн боловсруулж, сэтгүүлчид болон олон нийтэд зориулсан гарын авлагыг 300 хувь хэвлүүлсэн. Тогтвортой хөгжлийн мэдлэг олгох гарын авлагыг онлайн системд шилжүүлэн цахим ном хэлбэрээр www.nclc.mn сайтад байршуулж, олон нийт чөлөөтэй ашиглах боломжийг бүрдүүлсэн болно.

- Хэвлэл мэдээллийн салбарын сэтгүүлчид, төрийн байгууллагын албан хаагчид болон аж ахуйн нэгж байгууллагын хүмүүст зориулсан тогтвортой хөгжлийн мэдлэг олгох гарын авлагыг шинэчлэн боловсруулсан. Шинээр 25 сэтгүүлчийг үндэсний сургагч багшийн сургалтад хамруулан, сертификат олгосон бөгөөд 2016 онд бэлтгэгдсэн 15 үндэсний сургагч багшийг ахисан шатны сургалтад хамруулсан. Мөн байгаль орчны салбарын 30 мэргэжилтэнг хамруулсан төсөл бичих арга зүй сургалтыг 4-р сарын 10-12-ны өдрүүдэд зохион байгуулав. Энэ оны 5-р сарын 2-26-ны өдрүүдэд төрийн зарим байгууллагын албан хаагчдад зориулсан тогтвортой хөгжлийн мэдлэг олгох сургалт зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

5.2. Байгаль орчны удирдлагын MNS ISO14000 багц стандартыг аж ахуйн нэгж, байгууллагад нэвтрүүлэхийг хөхиүлэн дэмжиж, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хэрэглээний хэмнэлттэй зөв дадлыг бий болгох:

- Байгаль орчны удирдлагын тогтолцоо ISO 14000 багц стандартыг нэвтрүүлэх үндэсний стратегийг боловсруулсан бөгөөд байгаль менежментийн тогтолцооны

- Байгаль орчны менежментийн тогтолцоо. Шаардлага, хэрэглэх арга зүйн заавар ISO 14001
- Байгаль орчны удирдлага — Амьдралын мөчлөгийн үнэлгээ — Зарчим ба бүтэц ISO 14040
- Бүтээгдэхүүний тогтолцооны эко–үр ашгийн үнэлгээ — Зарчим, шаардлага ба арга зүйн заавар ISO 14045
- Байгаль орчны менежмент — Тайлбар толь ISO 14050
- Материал зарцуулалтын зардлын бүртгэл — Ерөнхий хүрээ ISO 14051 стандартыг боловсруулж, Стандартчилалын үндэсний зөвлөлийн хурлаар 2016 оны 11-р сард хэлэлцүүлж, Монгол Улсын үндэсний стандартаар батлууллаа.

- Аж ахуйн нэгж байгууллагуудад байгаль орчны удирдлагын тогтолцооны стандартыг аж ахуйн нэгж байгууллагуудад сурталчлан таниулах зорилгоор “Greening business DNA” форумыг 2016 оны 10-р сард зохион байгуулж, байгаль орчны удирдлагын тогтолцооны ISO 14001 стандартыг нэвтрүүлсэн “АПУ” ХХК, Материал зарцуулалтын зардлын бүртгэл ISO 14051 стандартыг нэвтрүүлсэн “Гүнгэрваа” ХХК –ны эдгээр стандартыг хэрэгжүүлсэн бодит үр дүнгээ бизнес эрхлэгчдэд танилцуулан сурталчилсан.

- СХЗГ-ын Бүтээгдэхүүн тогтолцооны баталгаажуулалтын зөвлөлийн хурлаар 2014 онд усны хайгуул, өрөмдлөгийн “Танан импекс” ХХК, 2017 онд хүнсний үйлдвэрлэлийн “Агь” ХХК-д Байгаль орчны менежментийн тогтолцоо MNS ISO 14001 стандартыг хэрэгжүүлсэн байдалд аудит явуулж, байгаль орчны менежментийн тогтолцоо нэвтрүүлсэн гэрчилгээ, тэмдэглэгээг олгосон.

ажиллагааны байгууллага болон эрдэмтэн, судлаач, мэргэжилтнүүдийн 110 гаруй төлөөлөл оролцон саналаа солилцсон.

- Дорнод аймгийн Чойбалсан хотыг Зүүн бүсийн тулгуур төв болгох хүрээнд хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг тодотгох, ногоон хот болгон шинэчлэн боловсруулах зураг төслийн ажлыг БНСУ-ын хөрөнгө оруулалттай “Кёнжин архитектур номад” ХХК, “Говь тревэл” ХХК-иудын түншлэлээр гүйцэтгүүлж Барилга, хот байгуулалтын сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлээд байна.

- Барилга хот байгуулалтын сайдын 2017 оны хоёрдугаар сарын 02-ны өдрийн 27 дугаар тушаалаар Төв аймгийн Сэргэлэн сумын Хөшигийн хөндийд баригдсан Олон улсын нисэх онгоцны шинэ буудлыг даган хөгжих хотын батлагдсан ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийг байгуулсан. Даган хөгжих хотыг ногоон, ухаалаг, тав тухтай амьдрах орчныг бүрдүүлсэн хот байхаар ерөнхий төлөвлөгөөг хийж ажлын хэсгийн гишүүдтэй санал солилцон ажиллаж байна.

- “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлага” баримт бичгийг УИХ-ын 2013 оны 02 сарын 8-ны өдрийн 23 дугаар тогтоолоор баталсан. “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх Ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлага” бодлогын баримт бичгийн хүрээнд нийслэлийн ирээдүйн хөгжлийг шинэ шатанд гаргах, нийслэл Улаанбаатар хотын хөгжилд тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэх, эдийн засгийн шинэ бодлогыг тодорхойлж, хөгжүүлэх, хотын иргэдийн амьдралын түвшинг дээшлүүлэх зорилготойгоор “Улаанбаатар хотын Ногоон хөгжлийн стратеги төлөвлөгөө 2020” баримт бичгийг боловсруулж НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 41 дүгээр тогтоолоор батлуулсан.

6.2. Хот, тосгоны газар ашиглалт, барилгажилтын бүсчлэл, дэд бүтцийн төлөвлөлтийг боловсронгуй болгон хэрэгжүүлэх, хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалтыг бий болгож агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулах арга замын хүрээнд:

- Барилга, хот байгуулалтын сайдын 2016.11.29-ний өдрийн Б/187 дугаар тушаалаар “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийн бүсчлэлийн тухай” хуулийн төсөл, үзэл баримтлалыг боловсруулах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг шинэчлэн байгуулсан. Хот байгуулалтын тухай хууль, Ногоон байгууламжийн тухай хуулиудыг санаачлан холбогдох яамдуудаас санал авлаа. Хуулийн төслийг ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлсэн ба олон нийтийн саналыг тусгах зорилгоор БХБЯ-ны сайтаар нээлттэй хэлэлцүүлж байна.

- БХБЯ, БОНХАЖЯ, НҮБХХ, НҮБ-ын Хүн амын нутагшилт, суурьшлын хөтөлбөр НҮБ-Хабитат, Ногоон эдийн засгийн төлөөх PAGE, Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллагууд хамтран 2016 оны 3 дугаар сарын 11-ний өдөр “Хот байгуулалтын форум”-ыг “Ногоон хот байгуулалт” сэдвийн дор зохион байгуулсан. Чуулганы үеэр хот, тосгоны дэд бүтцийн төлөвлөлтийг боловсронгуй болгох, суурьшлийн бүсээс үзүүлж байгаа агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулах чиглэлээр оролцогч, төлөөлөгч нар илтгэл хэлэлцүүлж, саналаа солилцсон.

- БХБЯам, Нийслэлийн ЗДТГ хамтран Япон Улсын Жайка байгууллагын дэмжлэгээр Улаанбаатар хотын ус хангамж, ариутгах татуургын стратеги

6.3. Улаанбаатар хот болон бусад хот, сууриныг дахин төлөвлөж эдэлбэр газарт ногоон байгууламжийн эзлэх хувь хэмжээг 2020 он гэхэд 15 хувь, 2030 он гэхэд 30 хувьд хүргэх хүрээнд хэрэгжүүлэх арга замын хүрээнд:

- Улаанбаатар хотын ногоон байгууламжийн мастер төлөвлөгөө боловсруулах ажлын санхүүжилт шийдэгдээгүйгээс хэрэгжээгүй. Гэхдээ “Улаанбаатар хотын ногоон хөгжлийн стратеги”-ийн төлөвлөгөө 2016 онд батлагдсан.

- 2017 оны ногоон байгууламжийн чиглэлээр хийх ажлын төлөвлөгөө, “Ногоон Улаанбаатар 2017-2020” хөтөлбөрийг боловсруулж тус хөтөлбөрт ногоон байгууламжийг нэмэгдүүлэхээр тодорхой ажлуудыг тусгаад байна. 2016 онд Нийслэлд нийт 200,0 мян.м² сул шороон хөрстэй газрыг зүлэгжүүлж, нийтдээ 4000 ширхэг мод тарьсан. Цэцэрлэгжилтийн мэргэжлийн хувийн хэвшлийн байгууллагуудтай гэрээ байгуулан хотын зарим гудамж, цэцэрлэгүүдийн ногоон байгууламжийн арчилгааны ажлыг гүйцэтгүүлсэн байна. Улаанбаатар хотын гудамж, талбайн ногоон байгууламжийг нөхөн сэргээхэд зориулан 2016 оны 4, 5-р сард 480,0 мянган ширхэг мод, сөөг нэмэж тарьсан. 2016 оны 4-р сарын дундуур хотын хэмжээнд 4000 ширхэг улиас модыг тайрч хэлбэржүүлэн, 4600 модыг шохойдож, 2016 оны 5, 6-р сард 152,0 мян.м² ногоон байгууламжийн хөрсийг ариутгах, 180,0 мян. ширхэг мод сөөгний өвчин, хортонтой тэмцэх, 900,0 мян.ш мод, сөөгийг бордох, 3500ш улиасны үрийн молцогийг гараар түүж унгарилыг багасгах, 250,0 мян/м² газрыг зүлэгжүүлэх, 20,0 мян/м² талбайд нэг наст цэцэг тарих ажлыг график, төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэсэн. “Асем-11” Олон улсын чуулга уулзалтын бэлтгэл ажлын хүрээнд УБ хотын төвийн 6 гудамжинд 1483 ширхэг торхтой болон том мод, бут сөөг тарив. “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-ийг хавар, намрын улиралд буюу 5, 10-р сард амжилттай зохион байгуулж хотын хэмжээнд нийт 268.0 мянган ширхэг мод, сөөг таригдаж БОАЖЯ-аас уриалсан “Нэг сая мод ургуулья” хөдөлгөөнд нийслэлчүүд идэвхтэй оролцов.

- "Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртлэх хөгжлийн чиг хандлага" баримт бичгийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг БХБЯ-аас боловсруулж Засгийн газрын 2016 оны 174-р тогтоолоор батлуулсан. Эдгээр баримт бичигүүдэд хотын ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэнг 3 дахин нэмэгдүүлэх заалт, арга хэмжээг тусгасан болно.

- БХБЯ-аас Хот тосгоны ногоон байгууламжийн тухай хуулийг санаачлан боловсруулаад байна. Нэг хүнд ноогдох ногоон байгууламжийн хэмжээ дэлхийн дунджаар 20-24 м² байх юм бол хэвийн ногоон хот гэж үздэг бол манай улсад энэ тоо дөнгөж 3,4 м² байна.

- Энэхүү зорилтоот ажил нилээд сайн хэрэгжиж байна. Тухайлбал: Орхон аймгийн Жаргалант сумын Засаг даргын А/330 дугаар захирамжийн дагуу “Шидэт номин” ХХК-ийн гүйцэтгэсэн 4х6 харьцаатай 17ш хүлэмжийг сумын айл өрхийн дунд хүнсний ногоо, мод бут, тариалахад хүлэмжийн аж ахуйн эрхлэгчдэд олгож хүлэмжийн аж ахуйн эрхлэх чадамж олгох сургалтыг “Рашаант-Үйлс” ТББ-тай хамтран зохион байгуулсан байна. Дархан-Уул, Дорнод, Дундговь, Увс аймгийн БОАЖГ-ын дэргэд байгуулсан мод үржүүлгийн газраас сумдуудад мод үржүүлгийн газар байгуулах аргачлал заавар өгч, үржүүлгийн газарт ургуулсан тарьц суулгацыг ойн нөхөн сэргээлт, цэцэрлэгжүүлэлтэд ашигладаг болсон бол Дундговь аймгийн БОАЖГ-ын дэргэд 2008 онд байгуулсан мод үржүүлгийн газарт 5,0 га -д улиас, сухай, бургас, хайлаас, голт бор, чацарганыг үрээр болон мөчрөөр үржүүлж жилдээ 40000 орчим говийн хөрсөнд дасан зохицсон тарьц, суулгац

зохион байгуулан, “Ногоон дэлхийгээ хайрлацгаая” эко сургалт зохион байгуултанд 340 сурагч, 98 албан хаагч 56 иргэн оролцуулжээ. Баян-Өлгий Хог хаягдлыг бууруулах, ангилан ялгах талаар орон нутгийн радио телевизээр ард иргэдэд сурталчилгааны ажлууд тогтмол хийгддэг болсон бол Увс аймгийн Улаанг ом хотын хог хаягдлын менежментийг сайжруулах зорилгоор хог хаягдлыг ангилан ялгах, цуглуулах, булж дарах, устгах ажлыг гүйцэтгэхээр Элемент ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж байна. Энэ ажилтай холбогдуулан Улаангом сумын орон нутгийн телевизээр тогтмол сурталчилгаа болон хог ачих хуваарь танилцуулж байна.

- Улаанбаатар хот “Хог хаягдлын менежментийг сайжруулах дэд хөтөлбөр” –т ерөнхий боловсролын сургуулийн 7-р ангиас хог хаягдлын менежментийн талаар лекц, сургалт орж эхэлсэн байхаар, Хүүхдүүдэд хог хаяхгүй байх талаар цогц ойлголтыг олгох хичээлийг ЕБС болон сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөрт тусгасан байхаар заасан. Төв аймаг 2016-2017 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсролын болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрт биологийн болон экологийн хичээлээр дамжуулан орчны бохирдлыг багасгах сургалтыг орж байна. Дорнод аймгийн Аймгийн Засаг даргын захирамжаар гаргасан сар бүрийн 1-нийг “Хүүхдээ сонсох өдөр” болгосон байна

6.5. Байгаль орчинд ээлтэй, хүртээмжтэй, найдвартай, эрсдэлгүй нийтийн тээврийн төрөл, үйлчилгээг хөгжүүлж, иргэд ая тухтай зорчих орчныг бүрдүүлэх ажлын хүрээнд хэрэгжүүлэх:

- ЗТХЯ-аас Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр 2016-2023 онд Хотын нийтийн тээврийн үйлчилгээнд тусгай замын автобус (BRT)-ыг нэвтрүүлэхээр төлөвлөн ажиллаж байгаа бөгөөд төлөвлөлтөөр хотын босоо тэнхлэг буюу “Нисэх - 7 буудал чиглэлд - 23 км”, Хэвтээ тэнхлэг “ХМК- 3,4 хороолол - Шархад чиглэлд - 19,5 км” буюу нийт 42,5 км замыг барьж байгуулах, 57км замыг засварлах, 146 тусгай замын автобус худалдан авах, 10 уулзварт өргөтгөлийн ажлууд хийгдэнэ. Төслийн нийт хөрөнгө оруулалт 274,4 сая ам.доллар бөгөөр үүнээс Азийн хөгжлийн банк 215,9 сая ам.доллар, Дэлхийн ногоон хөгжлийн банк 1,5 сая ам.доллар, 57сая ам.доллар Монгол Улсын Засгийн газраас хөрөнгө оруулалт хийгдэхээр төлөвлөглөсөн.

- Төслийн явц “Нийслэлийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн бэлтгэл ажлыг хангах, Азийн хөгжлийн банкны төслийн баг, судалгааны багуудын ажлыг дэмжих, шуурхай зохицуулалтаар хангах, хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад холбогдох техникийн шийдлийг гаргаж хамтран ажиллах үүрэг бүхий техникийн ажлын хэсэг байгуулагдсан. 2016 оны 2 сарын 26-ны өдөр тус ажлын хэсэг АХБ-ны төслийн баг, Нийтийн тээврийн чадавхийг бэхжүүлэх ТА8212-МОН болон Төр хувийн хэвшлийн түншлэлийн бэхжүүлэх ТА8985-МОН төслийн багтай уулзалт хийж АХБ-ны тусгай замын автобусны коридор сонголтын талаар саналтай танилцсан.

- “Нийтийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд Азийн хөгжлийн банкнаас техник туслалцааны дараах төслийг хэрэгжүүлж байна. Үүнд:

1. “Улаанбаатар хотын тээврийн чадавхийг бэхжүүлэх” ТА-8212 МОН
2. “Төр хувийн хэвшлийн түншлэл” ТА-8985 МОН

6.6. Явган хүн зорчих хэсэг, ногоон байгууламж, дугуйн зам, зогсоолын төлөвлөлт, зохион байгуулалтыг боловсронгуй болгож иргэд явган явах, дугуйгаар зорчих орон зайг нэмэгдүүлэх арга замын хүрээнд:

- Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/817 дугаартай захирамжаар Туул, Сэлбэ, Дунд голын урсацыг нэмэгдүүлж, эргийн дагуу олон нийтэд зориулсан эрүүл мэнд, соёл, амралтын тохилог орчин бүрдүүлэх талаар санал боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг зохион байгуулан ажиллаж байна. Ажлын хэсгийн хурлын шийдвэрээр Их тойруугийн гүүрнээс Голден вилл хотхоны гүүр хүртэл тохижилтын ажлыг иж бүрэн дуусгаж хүлээлгэн өгөх юм.

- Унадаг дугуй үндэсний хөтөлбөр боловсруулах, дугуйн замын судалгаа хийх ажлыг ЗТХЯ, Монголын автозамчин залуучуудын холбоо хамтран холбогдох яамдын оролцоотой ажлын хэсэг байгуулан хэрэгжүүлж эхлээд байна.

НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

- Ногоон хөгжлийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлж, бүх салбарт дэвшилтэт техник, технологи, инноваци нэвтрүүлж, байгалийн нөөц баялагийг үр ашигтай ашиглах, Засгийн газрын худалдан авалтыг байгаль орчинд ээлтэй, үр ашигтай, хэмнэлттэй, бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад чиглүүлэх, салбарын бүх яамд, төрийн байгууллагууд, хувийн хэвшил, олон нийтэд байгаль орчинд ээлтэй хэрэглээний дадлыг төлөвшүүлэхэд чиглэсэн арга хэмжээг байгууллага бүр хэрэгжүүлж, салбар бүр үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлэх,

- Монгол Улс уур амьсгалын өөрчлөлтөд өртөмтгий эмзэг орны хувьд уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг сааруулах дасан зохицох асуудлаарх үндэсний төлөвлөгөөг салбарын яамд, орон нутгийн байгууллагын оролцоог ханган бодитой арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх,

- Үндэсний хэмжээний ногоон зээлийн сан байгуулах асуудлыг шийдвэрлэж, Уур амьсгалын ногоон сан, Дасан зохицлын сан зэрэг олон улсын сан, санхүүжилтийн механизмаас санхүүжилт, дэмжлэг авах Үндэсний хэрэгжүүлэгч нэгж болох боломжийг бүрдүүлж, иргэд, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгальд ээлтэй, агаар, орчны бохирдол болон дулааны алдагдлыг бууруулах, эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн, цахилгаан халаагуур худалдан авахад дэмжлэг үзүүлэх, хүү багатай зээлийн бүтээгдэхүүн бий болгох,

- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангах шат дараалсан арга хэмжээг бүх шатны байгууллагууд хамтран авч хэрэгжүүлэх,

- УИХ-ын 2014 оны 43 дугаар тогтоолд заасны дагуу Тогтвортой хөгжлийн үндэсний хороо Ногоон хөгжлийн бодлого, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг салбар дундын уялдаатайгаар зохион байгуулах, салбарын яамд өөрсдийн чиг үүргийн дагуу туссан арга хэмжээний хэрэгжилтийг тодорхой бүтээгдэхүүн нийлүүлэх хэлбэрээр албан тушаалтанд хариуцуулан үйл ажиллагааны үр дүнд суурилсан тайланг Тогтвортой хөгжлийн үндэсний хороонд хүргүүлж байх.

БОАЖЯ